



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТАЙЛАН

Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлж, түр саатуулах болон төлбөртэй зогсоол эрхлэгч иргэн, ААНБ нь үйл ажиллагаагаа холбогдох журамд нийцүүлээгүй, түүнд тавих хяналт сул, журмын хэрэгжилт хангалтгүй байна.



АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ ТӨЛБӨРТЭЙ ЗОГСООЛ АЖИЛЛУУЛАХ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатар хот
2021 он

/НАГ-2021/89-ШТА-ГА/



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 1/35

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх хэсэг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Нийслэлд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, саатуулах, төлбөртэй зогсоол ажиллуулах журмын хэрэгжилт”-д хийсэн аудитын / НАГ-2021/89-ШТА-ГА/ тайлан, албан шаардлагыг баталгаажуулсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Г.Баярсайхан/ нарт тус тус зөвлөсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 6 дугаар сарын 15-ны дотор гаргаж танилцуулахыг Аудитын гурав дугаар хэлтэс /Э.Мөнхмандах/-д үүрэг болгосугай.

4. Тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010145

Аудитын тайланг бэлтгэсэн:

Товчилсон үг

4

Хүснэгтийн жагсаалт

Нийслэл дэх Төрийн аудитын газар. Аудитын III хэлтэс

Хавсралтын жагсаалт

5

Графикийн жагсаалт

Хэлтсийн дарга, аудитын менежер

Э.Мөнхмандах

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

6

Аудитын менежер

Л.Саранбаатар

Ерөнхий мэдээлэл

7

Бүлэг 1. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлж байна уу?

8

1.1 Нийслэл, дүүргийн ИТХ нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбоотой хамрах хүрээ, үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шаардлага, төлбөрийн хувь хэмжээ зэргийг тогтоох үүргээ хэрэгжүүлсэн үү?

8-10

1.2 Нийслэлийн Засаг дарга нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах аж ахуйн нэгж, байгууллагыг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан уу?

10-13

1.3 Гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагууд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахдаа журамд заасан шаардлагуудыг хэрэгжүүлж байна уу?

13-18

1.4 Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, шилжүүлсэн, саатуулсан тээврийн хэрэгслийн тоо, байршилтай холбоотой мэдээлэлд судалгаа шинжилгээ хийх замаар журмын зорилгыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна уу?

18-20

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г корпус. Утас: 327787

Тайланг <https://audit.mn/> веб сайтаас үзнэ үү.

Бүлэг 2. Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлж байна уу?

21

2.1 Нийслэлийн Авто замын газар нь нийтийн эзэмшлийн зам талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ үзүүлэх эрэлт, хэрэгцээг тооцож судлах, байгуулах үүргээ хэрэгжүүлсэн үү?

21-24

2.2 Төлбөртэй зогсоолын үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагуудтай

24-28

гэрээ байгуулах, хяналт тавих үүргээ
хэрэгжүүлсэн үү?

2.3 Төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа
эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагууд 28-29
журамд заасан үүрэг, шаардлагыг
хэрэгжүүлж байна уу?

Аудитын дүгнэлт	30
Аудитын зөвлөмж	31
Холбогдох байгууллагын санал	32
Саналд өгсөн тайлбар	32
Хавсралтууд	33-37

Товчилсон үг

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗЦГ	Замын цагдаагийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НАЗХГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
НГЗБА	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
НОБГ	Нийслэлийн Онцгой байдлын газар
НТА	Нийслэлийн Татварын алба
НТГ	Нийслэлийн Тээврийн газар
НШУУИГ	Нийслэлийн Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл инновацын газар
НҮНТ	Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв
НХТЕТГ	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТЦА	Тээврийн Цагдаагийн алба
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
УБЗЗА	Улаанбаатар зам засвар арчлалтын газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	8
Хүснэгт 2	Тээврийн хэрэгслийн зөөж, шилжүүлэх хамрах хүрээ	9
Хүснэгт 3	Тээврийн хэрэгслийн нэг явалтын зардлын тооцоолол	9-10
Хүснэгт 4	Жолооч болон тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага	11-12
Хүснэгт 5	Тээврийн хэрэгслийн бэлэн байдал	12-13
Хүснэгт 6	Зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгсэл	13
Хүснэгт 7	Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, саатуулах явцад гарсан зөрчил	15
Хүснэгт 8	Иргэдээс ирүүлсэн санал, гомдол	17
Хүснэгт 9	Төлбөртэй зогсоолын гэрээ байгуулсан иргэн, ААНБ	21
Хүснэгт 10	Зогсоолын талбай байгуулах судалгаа	22-23
Хүснэгт 11	Гэрээний дагуу орлого төвлөрүүлсэн байдал	25
Хүснэгт 12	Орлого дутуу төвлөрүүлсэн иргэн, ААНБ	26
Хүснэгт 13	1 Авто машины зогсоолын төлбөр	26
Хүснэгт 14	1 авто зогсоолын төлбөрийг гэрээгээр харилцан адилгүй тооцсон	27
Хүснэгт 15	Өөрийн эзэмшлийн талбайд, газрын зориулалтаа зөрчин авто зогсоол үйл ажиллагаа эрхэлсэн	27-28
Хүснэгт 16	Төлбөртэй зогсоолын талбай шаардлага хангаж буй эсэх	29
Хүснэгт 17	Төлбөртэй зогсоолын талбайд төлбөрийн систем байрлуулж төлбөр авч буй байдал	29

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлж, түр саатуулсан орлогын зарцуулалт /2020 он/	33
Хавсралт 2	1 авто машинаас орох орлогыг гэрээгээр харилцан адилгүй тооцсон	33-34
Хавсралт 3	Боловсон хүчний талаарх мэдээлэл /жолооч, техникийн ажилтан/	35
Хавсралт 4	Жолооч болон техникийн ажилтны цалинг хөдөлмөрийн гэрээнд тусгасан байдал	35
Хавсралт 5	Зогсоолын талбайн стандарт	36-37

Графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	Зөөж, шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тоо	18
График 2	Зөөж, шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тоог нийт тээврийн хэрэгслийн тоотой харьцуулсан байдал	18
График 3	Зөөж, шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тооны өсөлтийн хувь	19
График 4	Гэрээ байгуулсан авто зогсоолын тоо	23
График 5	1 авто машины зогсоолоос төлбөр тооцсон байдал	27

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2021 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн хийв.
Аудитын зорилт	Аудитын зорилт нь Нийслэлд тээврийн хэрэгслийг зөөх шилжүүлэх, саатуулах, төлбөртэй зогсоол ажиллуулах журмын хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. ✚ Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлсэн эсэх. ✚ Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад НИТХ, Нийслэлийн ЗДТГ, НАЗХГ, төлбөртэй авто зогсоолын үйлчилгээг төвийн 6 дүүрэгт гэрээгээр гүйцэтгэж буй 70 иргэн, ААНБ, тээврийн хэрэгслийг зөөх, тээвэрлэх, түр саатуулах үйлчилгээ эрхэлж буй 14 ААНБ-ын үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулан, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг III хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Жавзанпагма, аудитор З.Болд, Д.Дайриймаа, З.Баярбилэгт, О.Дашхонгор, Б.Ууганбилэг нар гүйцэтгэв. Аудитыг 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх:

Замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тогтоолоор *“Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”*-ыг баталжээ. Дээрх журамд 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дугаар тушаалаар баталсан *“Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”*-ын 9 дүгээр бүлэгт “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах” үйл ажиллагаатай холбоотой харилцааг тусган баталжээ.

Журмыг хэрэгжүүлэх хүрээнд нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, түгжрэл саатлыг бууруулах зорилгоор НИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 33/35 дугаар тогтоолоор замын хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх цагийн хуваарь, автомашины тоо, үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шаардлагыг тогтоож, төлбөрийн хувь хэмжээ, ачиж журамлах үйл ажиллагаа явуулах байршлыг баталжээ.

2020 оны эцсийн байдлаар авто тээврийн хэрэгслийг зөөх, шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагаа эрхлэхээр НАЗХГ-тай гэрээ байгуулсан 14 ААНБ 99 тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлтэйгээр үйл ажиллагаа явуулжээ.

Төлбөртэй зогсоол:

Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйлчилгээг бий болгож, зогсоолын ашиглалтыг сайжруулах, замын хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох, замын түгжрэл, саатлыг багасгах, зорилгоор НИТХ-ын 2009 оны 4/27 дугаар тогтоолоор “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ыг баталж, 2011 оны 7/66 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулжээ.

2020 оны эцсийн байдлаар төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэхээр төвийн 6 дүүргийн 73 байршилд 13 иргэн, 57 ААНБ НАЗХГ-тай гэрээ байгуулжээ. Гэрээ байгуулсан иргэн, ААНБ-ын гэрээг жил бүр шинэчилж, гэрээг дүгнэж ажилласан байна.

Эзэмшлийн газраа зориулалт бусаар ашиглаж зохих зөвшөөрөлгүйгээр төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхэлж буй 131 иргэн, ААНБ байна.

БҮЛЭГ 1: ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР СААТУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА УУ?

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд 2019-2020 оны байдлаар нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд НАЗХГ-тай “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах” гэрээ байгуулсан 14 ААНБ 99 тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл

						/Тоогоор/
№	Дүүрэг	ААНБ-ын тоо	Хамрах огноо	Нийт авто машины тоо	Авто машин /талбарт ашиглаж байгаа/	Ашиглаагүй
1	БГД	2	2020	17	17	0
2	БЗД	4		36	33	-3
3	СБД	2		26	26	0
4	СХД	2		3	4	1
5	ХУД	3		8	8	0
6	ЧД	1		9	6	-3
Нийт		14		99	94	-5

2019 онд 26,837 2020 онд 33,144 нийт 59,981 тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлжээ.

Аудитаар ААНБ-ын өдөр тутмын үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн түр саатуулах 14 хашаа /байр/, тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлэх тусгай зориулалтын 99 тээврийн хэрэгсэл, жолооч, техникийн ажилчид, “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо” ТББ-ын ашиглаж буй www.auto-ub.com программын явцтай танилцлаа.

НИТХ-ын 2015 оны 33/35 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлд тээврийн хэрэгслийг зориулалтын авто машинаар зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах журам”-аар тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашааны төлбөрийн хувь хэмжээг тээврийн хэрэгслийн төрлөөс хамааран 30.0-90.0 мянган төгрөг байхаар тогтоожээ.

1.1 Нийслэл, дүүргийн ИТХ нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбоотой хамрах хүрээ, үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шаардлага, төлбөрийн хувь хэмжээ зэргийг тогтоох үүргээ хэрэгжүүлсэн үү?

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 9.1¹, 9.2²-д зааснаар НИТХ тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбоотой хамрах хүрээ, үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шаардлага, төлбөрийн хувь хэмжээг тогтоодог.

НЗД-ын 2015 оны 02-01/3467 дугаартай албан бичгээр ирүүлсэн тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйлчилгээ эрхлэхтэй холбоотой саналын дагуу НИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 33/35 дугаар тогтоолоор ачиж

¹ 9.1.Аймаг, нийслэл, сумын Засаг дарга нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтад заасан үүргийн хүрээнд түгжрэл саатлыг бууруулах зорилгоор тээврийн хэрэгсэл түр зогсохыг хориглох гудамж зам, хамрах хүрээ, үйлчлэх цагийн талаарх саналаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

² 9.2.Аймаг, нийслэл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 9.1-д заасан саналыг хэлэлцэж, тухайн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл түр зогсохыг хориглох гудамж, зам, түүний хамрах хүрээ, түр саатуулах хашаа /байр/-ны тоо, хашааны зогсоолын талбайн хэмжээг тогтоосон журам батлах

журамлах үйл ажиллагаа явуулах гудамж, замуудын жагсаалт, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх болон тусгай хашаа /байр/-ны үйл ажиллагааны төлбөрийн хувь хэмжээг тус тус баталсан.

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбоотой хамрах хүрээний 73 байршлыг дараах байдлаар баталжээ.

Хүснэгт 2. Тээврийн хэрэгслийн зөөж, шилжүүлэх хамрах хүрээ

№	Дүүрэг нэр	Байршлын тоо	Гудамж замын нэр
1	БГД	12	Энх тайвны өргөн чөлөө-Баруун 4 замын Нарны гүүр, Үндсэн хуулийн гудамж Энгелисийн гудамж хүртэл
2	БЗД	12	Энх тайвны өргөн чөлөө- Арслантай гүүрнээс Токиогийн гудамж хүртэл
3	СБД	24	Энх тайвны өргөн чөлөө-Арслантай гүүрнээс Чойдогийн гудамж хүртэл
4	СХД	3	Москвагийн гудамж, Ард Аюушийн өргөн чөлөөнөөс Товчооны зам, Л.Энэбишийн өргөн чөлөөнөөс Зурагтын хуучин эцэс хүртэл
5	ЧД	17	Энх тайвны өргөн чөлөө-Төв шуудангийн уулзвараас С.Чоймболын гудамж хүртэл
6	ХУД	5	Дунд голын гудамжнаас Нарны замаас Нийслэл хүрээ өргөн чөлөө хүртэл
Нийт		73	

Хүснэгтээс харахад төвийн бүс буюу СБД, ЧД-т 41 байршил буюу 56.1% нь хамрагдаж байна. Энэ нь хотын төвийн замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх, замын түгжрэлийг багасгах ач холбогдолтой байна.

Дээрх тогтоолын 3 дахь заалтад ачилтын үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах ерөнхий шаардлагыг *“Зориулалтын чирэгч, ачигч автомашины нийт тоо 100-аас ихгүй, түр саатуулах хашаа /байр/ тус бүрийн нийт талбай нь 2000 м/кв-аас доошгүй байх”*-аар тогтоосон байна.

НАЗХГ-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа 14 ААНБ нь 99 тээврийн хэрэгсэлтэйгээс 94 нь ачиж журамлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Эдгээр 14 ААНБ-ын хашааны хэмжээ 2000м²-аас багагүй байгаа нь гэрээ байгуулах ерөнхий шаардлагыг хангажээ.

НИТХ-ын 2015 оны 33/35 тоот тогтоолоор тээврийн хэрэгсэл зөөж, шилжүүлэх болон түр саатуулах хашаа /байр/ -ны төлбөрийн хувь хэмжээг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- Мотоцикл – 30.0 мянган төгрөг
- Суудлын автомашин – 60.0 мянган төгрөг
- Том оврын автомашин, автобус – 90.0 мянган төгрөг

Төлбөрийн хувь хэмжээг тогтооход Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”; Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар баталсан “Авто тээврийн жишиг тооцоо, жишээ аргачлал”-ын хүрээнд зориулалтын ачигч/чирэгч авто машин ашиглан тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх нэг удаагийн эргэлтийн хувьсах болон тогтмол зардлыг харгалзан 61,058 мянган төгрөг гэсэн дундаж тооцоог хийжээ.

Хүснэгт 3. Тээврийн хэрэгслийн нэг явалтын зардлын тооцоолол

Зардлын төрөл	Мөнгөн дүн /төг/	Хувь
Жолооч,техник ажилтан	13,000	21.3%
Удирдлагын зардал	9,807	16.1%
Тээврийн хэрэгслийг түр саатуулах байрны түрээс /газар/	8,333	13.6%
Ашиг	7,240	11.9%

Шатахуун зардал	6,444	10.6%
НӨАТ	5,550	9.1%
Авто машин элэгдэл	4,980	8.2%
НДШ	2,730	4.5%
Сэлбэг	1,280	2.1%
Дугуйн элэгдэл	1,050	1.7%
Шатах тослох материал	644	1.1%
Нийт	61,058	

НИТХ-ын 2015 оны 33/35 тоот тогтоолд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тээврийн хэрэгслийн төрлөөс хамааран 30.0, 60.0, 90.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Аудитаар НАЗХГ болон “Ачигч авто машины холбоо” ТББ-аас 2020 онд ачигдсан тээврийн хэрэгслийн тоон мэдээг авч дээрх задаргааны дагуу тооцоолол хийхэд дараах дүнтэй байна.

2020 онд 14 ААНБ 33,144 тээврийн хэрэгслийг тээвэрлэж 1,988.6 сая төгрөгийн нийт орлого олсон байна. Хавсралт 1.

2021 онд “Ачигч авто машины холбоо” ТББ тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлж, түр саатуулах үйл ажиллагаанаас орох орлогын 10 хувийг төсөвт төвлөрүүлэх талаар тооцоо судалгаа хийж 2020.03.24-ний 03/07, 2021.02.09-ний 07/02 дугаартай албан бичгүүдийг НАЗХГ-т хүргүүлсэн ч тодорхой шийдвэр гаргаагүй байна.

Тогтоолын 1 дүгээр хавсралтын “Ачиж журамлах үйл ажиллагаа явуулах гудамж, замуудын жагсаалт”-ын нэр дугаар, утга найруулгын алдааг засах, /БГД-ийн хамрах хүрээг ЧД гэж гарчигласан/, хэрэглэгчдэд ойлгомжтой болгох шаардлага байна.

Дүгнэлт: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбоотой хамрах хүрээ, үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шаардлага, төлбөрийн хувь хэмжээ зэргийг тогтоох үүргээ хэрэгжүүлсэн байна.

1.2 Нийслэлийн Засаг дарга нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах аж ахуйн нэгж, байгууллагыг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан уу?

“Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 9.2³-т тусгасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж, ахуйн нэгж, байгууллагатай ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулдаг байна.

НЗД-ын 2016 оны А/35, 2017 оны А/601 дүгээр захирамжаар тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгжүүдтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг НАЗХГ-т даалгажээ.

Үүний дагуу НАЗХГ-аас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ААНБ-ыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2015, 2016 онд зохион байгуулж, нийт 18 ААНБ-тай гэрээ байгуулсан. 2019, 2020 онд шинээр ААНБ-тай гэрээ байгуулаагүй, өмнөх гэрээ байгуулсан ААНБ-аас 14-ийн гэрээний хугацааг сунгажээ.

³ 9.2.Аймаг, нийслэл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 9.1-д заасан саналыг хэлэлцэж, тухайн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл түр зогсоохыг хориглох гудамж, зам, түүний хамрах хүрээ, түр саатуулах хашаа /байр/-ны тоо, хашааны зогсоолын талбайн хэмжээг тогтоосон журам батлах бөгөөд аймаг, нийслэл, сумын Засаг дарга нь энэхүү шийдвэрийн дагуу тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж, ахуйн нэгж, байгууллагатай ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, түүнд дараах зүйлийг тусгана:

ХЗС-ын 2015 оны А/190 дүгээр тогтоолын 3.4⁴ дэх заалт, “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 9.2.2⁵, 9.3⁶, 9.16⁷, 9.26⁸-д, зааснаар үйлчилгээ эрхлэх ААНБ-ын түр саатуулах талбайн хэмжээ нь 2000 ам метр-ээс доошгүй байх, өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлтэй, жолооч нар нь мэргэшсэн, түр саатуулах байр нь харуул хамгаалалттай, галын аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянах камерын хяналтын системтэй, ил болон битүү зогсоолын хүрэлцэхүйц талбайтай, хашаа нь тортой, гэрэлтүүлэгтэй, холбоо мэдээллийн хэрэгслээр хангагдсан байх зэрэг шалгуур үзүүлэлтийг тусгажээ.

Аудитаар дээрх 14 ААНБ-ын түр саатуулах хашаа /байр/-ыг газар дээр нь шалгахад өөрийн эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулдаг 1, түрээсийн хашаанд үйл ажиллагаа явуулдаг 13 ААНБ байна. Эдгээр ААНБ-ын түр саатуулах талбайн хэмжээ нь 2000 ам метр-ээс доошгүй байх шаардлагыг хангасан байна. Мөн түр саатуулах хашааг бүрэн камержуулж, гэрэлтүүлсэн, харуулын ажлын байраар хангасан, хашааг битүү торлосон, 3 ээлжийн харуул хамгаалалтын ажилтныг ажиллуулсан, холбоо мэдээллийн хэрэгслээр бүрэн хангагдсан нь журмын шаардлагад нийцжээ.

Харин тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн бэлэн байдал, жолоочийн мэргэшсэн байдал, туршлагыг шалгахад шалгуур хангаагүй зарим зөрчил илэрлээ. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн 30 буюу 31.9% нь /10 ААНБ-д хамаарах/ бусдын эзэмшилд байгаа нь өөрийн эзэмшлийн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх шаардлага хангаагүй;
- 6 ААНБ-ын 10 жолооч Е ангилалгүй;
- 8 ААНБ-ын 11 жолооч мэргэшээгүй байна.

Хүснэгт 4. Жолооч болон тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага

№	ААНБ-ын нэр	Нийт авто машины тоо /талбарт/	Автомашин эзэмшигч		С ангилалтай мэргэшсэн жолоочгүй	Е ангилалтай мэргэшсэн жолоочгүй	СЕ ангилалтай мэргэшсэн жолоочгүй	3-аас доошгүй жил жолоодсон, дадлага, туршлагатай, мэргэшсэн жолоочгүй
			Өөрийн	Бусдын				
1	Булган ЖАЦО ХХК	6	-	6	1	3	3	1
2	Тэнгэрлэг наяд групп ХХК	4	1	3	-	-	-	3
3	Бат зэв ХХК	15	15	-	-	-	-	-
4	Дабль эйт ХХК	4	4	-	-	1	-	1
5	Сидней констракшн монголиа ХХК	4	4	-	2	2	2	2
6	Авто хүч ХХК	4	-	4	-	-	-	-

⁴ 3.4 дэх заалт Тээврийн хэрэгслийн түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах байгууллага нь өөрийн эзэмшлийн зориулалтын чирэгч, ачигч автомашинтай байна. Зөөж шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор жолоочоос гадна техникийн ажилтан ажиллуулна.

⁵ 9.2.2.тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үеийн аюулгүй ажиллагаа, зохион байгуулалт, хориглох зүйл, төлбөрийн хэмжээ, харуул хамгаалалт болон хашаанд тавигдах шаардлага, харуулын ээлжийг хүлээлцэх, тээврийн хэрэгслийг хүлээн авах, жолооч /эзэмшигч, өмчлөгч/-д хүлээлгэн өгөх ажиллагаа, тээврийн хэрэгсэл, түүний ачаа тээшний хадгалалттай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх, тээврийн хэрэгсэл битүүмжлэн хадгалсны төлбөр, бусад зүйлийг.

⁶ 9.3.Тээврийн хэрэгслийн түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах байгууллага нь өөрийн эзэмшлийн зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгсэлтэй байна. Зөөж шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор жолоочоос гадна техникийн ажилтан ажиллуулна.

⁷ 9.16.Тусгай зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгслийн жолооч нь СЕ эсхүл С1Е ангилалтай тээврийн хэрэгслийг 3-аас доошгүй жил жолоодсон, дадлага, туршлагатай, мэргэшсэн жолооч байх бөгөөд цагдаагийн ажилтнаас тээврийн хэрэгсэл түр саатуулах, зөөж шилжүүлэх талаар бичгээр буюу цахим хэлбэрээр өгсөн шийдвэрийн дагуу техникийн ажилтны тусламжтайгаар дараах ажиллагааг хийнэ:

⁸ 9.26 Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ нь даатгалтай, харуул хамгаалалтын ажилтантай, ил болон битүү зогсоолын хүрэлцэхүйц талбайтай, хашаа нь тортой, галын аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянах боломж бүхий камерын хяналтын системтэй, харанхуй үед үзэгдэх боломжийг хангасан гэрэлтүүлэгтэй, харуулын ажиллах нөхцөлийг хангасан ажлын байртай, холбоо, мэдээллийн хэрэгслээр тоноглогдсон байна.

7	Авто гоулд транс ХХК	6	-	6	-	-	-	-
8	Би Икс Юу Ти ХХК	6	5	1	-	-	-	-
9	Бодь транс ХХК	3	-	3	1	1	1	1
10	Баян хаяабуса ХХК	4	-	4	-	-	-	-
11	Успех ХХК	11	10	1	3	2	3	2
12	Их тээвэр ХХК	10	10		1	1	1	1
13	Энергэтикланд ХХК	6	5	1	-	-	-	-
14	Юу Эн Пи Эм Жи Эл ХХК	11	10	1	-	-	-	-
Нийт		94	64	30	8	10	10	11

НАЗХГ болон үйлчилгээ эрхлэгч нарын хооронд байгуулсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ”-ний 4.1-т тусгай зориулалтын автомашинд тавигдах шаардлагыг тусгажээ. Үүнд:

- 4.1.1 Зөөж шилжүүлж байгаа тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зориулалтын автомашины үйлдвэрлэснээс хойших ашиглалтын хугацааг тооцсон, үйлчилгээ явуулж болох баталгааг оношилгооны газраар гаргуулсан байх.
- 4.1.2 Автомашины бүхээг болон тэвшин дээр байгууллагын нэр, таних тэмдэг, үйл ажиллагааны чиглэл, утас бүхий мэдээллийг байрлуулах
- 4.1.3 Тусгай дуут болон гэрлэн дохио, холбооны хэрэгсэл, гэрэлтүүлгийн хэрэгслээр тоноглогдсон, зөвшөөрөлтэй байх.
- 4.1.4 Автомашиныг хөдөлгөөнгүй байлгах ивүүр, дэгээ, нэмэлт дугуй, бэхэлгээний бусад тусгай хэрэгслээр тоноглогдсон байх
- 4.1.5 Зориулалтын автомашин нь орчин үеийн техникийн шаардлагад нийцсэн урагшаа, хойшоо харсан дүрс бичлэгийн төхөөрөмжтэй байх.
- 4.1.6 Элс, шаварт суусан, зорчих хэсгээс замын хажуу тийш гарч зогссон, бусад хэлбэрээр өөрийн хүчээр замын зорчих хэсэгт гарах, хөдөлгөөнөө үргэлжлүүлэх боломжгүйгээр зогссон тээврийн хэрэгслийг чирч, зорчих хэсэг дээр гаргах зориулалтын өргөгч төхөөрөмж, дамран татлагаар тоноглогдсон, тээврийн хэрэгслийг өөр дээрээ ачих боломжтой, бусад нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслүүдтэй байх

Аудитаар ААНБ-ын 99 авто машины бэлэн байдлыг газар дээр нь шалгахад 5 тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцдоггүй бөгөөд давхардсан тоогоор нийт 36 зөрчил илэрлээ. Үүнд:

- Үзлэг оношилгоонд хамрагдаагүй 3 тээврийн хэрэгсэл /“Бодь транс” ХХК, “Их тээвэр” ХХК, Бат зэв ХХК-ний 3 авто машин;
- Урагш болон хойшоо харсан дүрс бичлэгийн төхөөрөмж /камер/-гүй 21 тээврийн хэрэгсэл;
- Автомашиныг хөдөлгөөнгүй байлгах ивүүргүй 5, татлагагүй 3, бэхэлгээгүй 4 тээврийн хэрэгсэл байна.

Хүснэгт 5. Тээврийн хэрэгслийн бэлэн байдал

№	ААНБ-ын нэр	Нийт авто машины тоо /талбарт/	Оношилгоонд ороогүй	Урд, хойно камергүй	Ивүүргүй	Татлагагүй	Бэхэлгээгүй	Нийт зөрчил тоо
1	Авто Гоулд Транс ХХК	6	-	-	1	1	2	4
2	Авто Хүч ХХК	4	-	4	-	-	-	4
3	Бат зэв ххк	15	1	1	1	1	1	5
4	Баян хаяабуса ХХК	4	-	2	-	-	-	2
5	Би Икс Юу Ти ХХК	6	-	-	-	-	-	-

6	Бодь транс ХХК	3	1	1	-	-	-	2
7	Булган жацо ХХК	6	-	6	1	-	-	7
8	Дабль эйт	4	-	-	-	-	-	-
9	Их тээвэр ХХК	10	1	1	1	1	1	5
10	Сидней констракшн Монголиа	4	-	1	-	-	-	1
11	Тэнгэрлэгнаяд групп ХХК	4	-	3	-	-	-	3
12	Успех ХХК	11	-	2	-	-	-	2
13	Энергэтикланд	6	-	-	1	-	-	1
14	Юу эн пи эм жи эл ххк	11	-	-	-	-	-	-
	<i>Нийт</i>	94	3	21	5	3	4	36

Дээрх 14 ААНБ-аас 10 ААНБ нь түр саатуулах хашаа байраа даатгуулсан, “Бат зэв”, “Бодь транс”, “Авто хүч”, “Булган жацо” ХХК-нь даатгуулаагүй нь Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журмын 9.269 дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд илэрсэн зөрчлүүдийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: Аудитын хамарсан хугацаа буюу 201-2020 онд НАЗХГ-аас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах ААНБ-ыг сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулаагүй байна. Харин гэрээ байгуулсан 14 ААНБ-ын гэрээний хугацааг сунгахдаа журмын шаардлагыг бүрэн мөрдүүлээгүй байна.

1.3 Гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагууд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахдаа журамд заасан шаардлагуудыг хэрэгжүүлж байна уу?

“Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 9.5¹⁰, 9.6¹¹, 9.7¹², 9.9¹³, 9.12.1¹⁴, 9.16.1¹⁵, 9.16.2¹⁶-дахь заалтууд тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлэх, түр саатуулах шаардлагуудыг тусгажээ.

2019 онд 26,837 2020 онд 33,144 нийт 59,981 тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлжээ.

Хүснэгт 6. Зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгсэл

№	Дүүрэг нэр	ААНБ-ын тоо	Машины тоо	Хамрах огноо		Өөрчлөлтийн хэмжээ /тоо/	Өсөлтийн хувь
				2019	2020		
1	БГД	4	7	6,464	5,984	-480	-7.4%

⁹ 9.26.Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ нь даатгалтай, харуул хамгаалалтын ажилтантай, ил болон битүү зогсоолын хүрэлцэхүйц талбайтай, хашаа нь тортой, галын аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянах боломж бүхий камерын хяналтын системтэй, харанхуй үед үзэгдэх боломжийг хангасан гэрэлтүүлэгтэй, харуулын ажиллах нөхцөлийг хангасан ажлын байртай, холбоо, мэдээллийн хэрэгслээр тоноглогдсон байна.

¹⁰ 9.5.Цагдаагийн байгууллага нь тээврийн хэрэгслийг түр саатуулсан, зөөж шилжүүлсэн тухай мэдээллийг лавлах утсаар авах боломжоор хангах, энэ тухай иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах бөгөөд тээврийн хэрэгслийг саатуулах үед эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн гар утасны дугаарт мессежээр мэдэгдэж болно.

¹¹ 9.6.Нийслэлд замын цагдаагийн нэгж, орон нутагт тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага тээврийн хэрэгсэл түр саатуулах, зөөж шилжүүлэх үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж ажиллана.

¹² 9.7.Цагдаагийн алба хаагч нь Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.4 дэх хэсэг, 33, 34 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх шийдвэрийг бичгээр буюу цахимаар гаргана.

¹³ 9.9.Энэ журмын 9.7-д заасан “цахимаар шийдвэр гаргах” гэдэгт тухайн тээврийн хэрэгслийн байгаа газарт албан хаагч байхгүй тохиолдолд тээврийн хэрэгслийн байрлал, орчныг бүрэн хамруулсан зураг-дүрс бичлэгийг цахим төхөөрөмжөөр хүлээн авч, шийдвэрлэхийг ойлгоно

¹⁴ 9.12.1.тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхийн өмнө болон шилжүүлэхээр бэлтгэж байх /ивүүр, татлага, бэхлэгээ хийх/ явцад тухайн тээврийн хэрэгслийн жолооч /эзэмшигч, өмчлөгч/ ирвэл шийтгэл оногдуулж, тээврийн хэрэгслийг хүлээлгэж өгөх

¹⁵ 9.16.1¹⁵. зөөж шилжүүлэх ажиллагааг эхлэхийн өмнө анхааруулах зорилгоор 3-аас доошгүй удаа чанга яригчаар зарлан мэдэгдэх;

¹⁶ 9.16.2 зөөж шилжүүлэх явцад тээврийн хэрэгсэл савж, гулсаж унахаас сэргийлж ивүүр, татлага, бэхлэгээ хэрэглэх;

2	БЗД	4	23	6,596	8,188	1,592	24.1%
3	СБД	2	24	11,029	14,101	3,072	27.9%
4	СХД	1	9	349	189	-160	-45.8%
5	ХУД	2	12	1,382	1,885	503	36.4%
6	ЧД	1	24	1,017	2,797	1,780	175.0%
Нийт		14		26,837	33,144	6,307	23.5%

2020 онд зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тоо хэмжээг өмнөх онтой харьцуулахад 23.5%-иар өссөн. Нийт ачилтын 41.8%-ийг СБД эзэлж байгаа нь нэг талаас тээврийн хэрэгслийн тоо жил бүр өссөн, хотын төвийн хэт төвлөрөл, нийтийн эзэмшлийн талбай дахь авто зогсоолын хүрэлцээгүй байдалтай холбоотой байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар замын хөдөлгөөний дүрэм зөрчин зөөж, шилжүүлэгдсэн авто машин нийслэлийн хэмжээнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 5.97%-ийг эзэлж байна.

НАЗХГ болон “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо” ТББ хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо” ТББ “Үндэсний дата төв” УТҮГ-ын хооронд “Төрийн мэдээлэл солилцооны систем ашиглах гэрээ”-г 2020 онд байгуулж www.auto-ub.com программыг ашиглаж эхэлжээ. Энэ программ нь дараах давуу талтай байна. Үүнд:

Ачиж журамлах зөвшөөрөл өгч буй цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг НАЗХГ, холбоо болон дээд шатны удирдлага нь цахимаар бүрэн хянах боломжтой болсон
Өмнө нь 73 байрилд 73 цагдаа ажилладаг байсан, программ нэвтэрснээр 2 цагдаа цахимаар ажилладаг болсон

Тухайн авто машины салхины шилэн дээрх дугаараар иргэдэд шуурхай мессеж илгээдэг
Ачигдсан тээврийн хэрэгслийн нэгдсэн мэдээллийн сан үүссэн
Ачилт хийж байх үеийн фото зургийг баримтжуулж программд байршуулснаар ачилтын явцад эвдрлэл гэмтэл үүссэн бол хохирлыг нөхөн төлдөг болсон

Үндэсний дата төвийн "ХУР" системтэй холбогдсоноор авто машины хуурамч улсын дугаарыг илрүүлдэг болсон
Smartcar.mn цахим хуудасны ачилт хэсэгт хандахад ачигдсан авто машин нь хаана ямар журмын хашаа /байр/-нд байршсан мэдээлэл бий болсон

Журмын 9.5¹⁷, 9.6¹⁸-д заасан тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбоотой үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавих чиг үүргийг Цагдаагийн байгууллага хариуцахаар зохицуулсны дагуу “Тээврийн цагдаагийн алба” болон “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо” ТББ-ын хооронд 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдөр №20/20 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулжээ.

Тус гэрээний дагуу Тээврийн цагдаагийн албаны албан хаагчид ажлын 5 өдрөөр 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр ээлжлэн “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо”-ны ажлын байранд байрлаж www.auto-ub.com программаар замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлэх түр саатуулж буй үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухайн ачигч байгууллагын техникийн ажилтан дүрс бичлэгээр баталгаажуулан, 3 удаа зарлан мэдээлсний дагуу программд оруулахад шийдвэрийг цахим хэлбэрээр 1-5 минутын дотор шуурхай шийдвэрлэн ажиллажээ.

Аудитаар замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 61 тээврийн хэрэгслийг 8 ААНБ-аас зөөж шилжүүлэхдээ журмын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгааг тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

¹⁷ 9.5.Цагдаагийн байгууллага нь тээврийн хэрэгслийг түр саатуулсан, зөөж шилжүүлсэн тухай мэдээллийг лавлах утсаар авах боломжоор хангах, энэ тухай иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах бөгөөд тээврийн хэрэгслийг саатуулах үед эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн гар утасны дугаарт мессежээр мэдэгдэж болно.

¹⁸ 9.6.Нийслэлд замын цагдаагийн нэгж, орон нутагт тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага тээврийн хэрэгсэл түр саатуулах, зөөж шилжүүлэх үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж ажиллана.

- Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхээр бэлтгэж байх явцад 17 авто машины жолооч ирж, ачилт хийлгүй хүлээлгэн өгсөн;
- www.auto-ub.com программыг гар утсанд суулган цагдаагийн алба хаагчийн шийдвэрийг үндэслэсэн эсэхийг шалгахад техникийн ажилтны авсан фото зураг, зөрчлийн мэдээллийн дагуу 14 тээврийн хэрэгслийг цагдаагийн алба хаагчийн албан ёсны шийдвэрээр ачилт хийсэн;
- 8 авто машиныг зөөх тээвэрлэх үйл ажиллагааг /3 удаа зарлан мэдээлж, ивүүр, татлага, бэхэлгээ хэрэглэн, фото зургаар баримтжуулан, цагдаагийн алба хаагчийн зөвшөөрөлтэй/ журмын дагуу явуулсан.
- Зөөж шилжүүлж, саатуулагдаж буй авто машины салхины шилэн дээрх утасны дугаарт тухайн тээврийн хэрэгслийг хаана саатуулж байгааг мэдээлж байсан.
- Өглөө 08.00 цагаас орой 20.00 цагийн хооронд ачилтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.
- Харин тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхийн өмнө журамд зааснаар 3 удаа зарлан мэдээлж байгаа ч тухайн тээврийн хэрэгслийн дугаарыг тод, чанга биш иргэдэд сонсогдоход бүдэг байдлаар зарласан, 8 авто машиныг зөөж шилжүүлэхдээ татлага, бэхэлгээ хийгээгүй зөрчил илэрсэн.


**Хүснэгт 7. Тээврийн хэрэгслийг зөөж
шилжүүлэх, саатуулах явцад гарсан зөрчил**

№	ААНБ-ын нэр	Тусгай зориулалтын авто машины улсын дугаар	Саатуулагдсан авто машины улсын дугаар	Зөөж шилжүүлэх үед жолооч ирсэн эсэх	Татлага, бэхэлгээ хийсэн эсэх
1	Успех ХХК	0064УАА	5890УНП	Үгүй	Үгүй
2	Би Икс Юу Ти ХХК	0331УАА	4518БНА	Үгүй	Үгүй
3	Успех	1226УНТ	5287УБС	Үгүй	Үгүй
4	Успех	0064УАА	4411УНӨ	Үгүй	Үгүй
5	Успех	0064УАА	6181УНО	Үгүй	Үгүй
6	Успех	0064УАА	3455УНЕ	Үгүй	Үгүй
7	Дабль Эйт ХХК	6273УБЛ	9224УБЦ	Үгүй	Үгүй
8	Батзэв ХХК	6361УБО	0217УНЧ	Үгүй	Үгүй

Зураг 1.Татлага бэхэлгээ хэрэглэлгүйгээр тээврийн хэрэгслийг зөөж буй байдал



2021 оны 6 сарын 25-ны өдөр 14:08 цагт Успех ХХК-ийн 1226УНТ дугаартай ачигч автомашин 5287 УБС дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.



2021 оны 6 сарын 28-ны өдөр 16:24 цагт Успех ХХК-ийн 4467УБЛ дугаартай ачигч автомашин 4775 УАР дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.



2021 оны 6 сарын 24-ны өдөр 13:33 цагт Успех ХХК-ийн 0064УАА дугаартай ачигч автомашин 5890 УНП дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.



2021 оны 6 сарын 17-ны өдөр 10:30 цагт Би Икс Юу ХХК-ийн 0331УАА дугаартай ачигч автомашин 4518 БНА дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.



2021 оны 6 сарын 28-ны өдөр 16:50 цагт Успех ХХК-ийн 0064УАА дугаартай ачигч автомашин 6181 УНО дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.



2021 оны 6 сарын 25-ны өдөр 16:25 цагт Дабль эйт ХХК-ийн 6273УБЛ дугаартай ачигч автомашин 9224 УБЦ дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.



2021 оны 8 сарын 19-ны өдөр 11:47 цагт Бат Зэв ХХК-ийн 6361 УБО дугаартай ачигч автомашин 0217 УНЧ дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.



2021 оны 8 сарын 23-ны өдөр 16:07 цагт Успех ХХК-ийн 0064 УАА дугаартай ачигч автомашин 3455 УНЕ дугаартай автомашиныг тээвэрлэсэн байдал.

Ажиглалтаар 1 авто машиныг 1-2 минутын хугацаанд ачиж тээвэрлэж байсан бөгөөд хугацааг журмаар зохицуулаагүй байна.

Тээврийн хэрэгслээ ачиж журамлуулсан иргэдээс НАЗХГ-т ирүүлсэн гомдол мэдээлэлтэй танилцахад 2020 онд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхтэй холбоотой 280 өргөдөл, гомдол бүртгэгдсэн байна. Нийт гомдлын дийлэнхийг тээврийн хэрэгслийг саатуулахдаа 3 удаа зарлаагүй, тухайн газраар үйлчлүүлээд 1 минут болоогүй байхад ачсан, машинаа байршуулахдаа дүрэм зөрчөөгүй гэсэн гомдол эзэлж байна.

Хүснэгт 8. Иргэдээс ирүүлсэн санал, гомдол

№	ААНБ-ын нэр	Ирсэн өргөдөл гомдол	Шийдвэрлэсэн өргөдөл гомдол	Зөрчил үүссэн өргөдөл гомдол	Төлбөр буцаан олголт хийгдсэн
1	ТС-1 “Юу Эн Эм Жи Эл” ХХК	6	6	0	0
2	ТС-2 “Батзэв” ХХК	50	50	6	0
3	ТС-3 “Авто хүч” ХХК	0	0	0	0
4	ТС-4 “Их тээвэр” ХХК	13	13	1	1
5	ТС-5 “Би Икс Юу Ти” ХХК	25	25	5	2
6	ТС-6 “Авто гранд мастер” ХХК	7	7	1	0
7	ТС-8 “Бодь транс” ХХК	20	20	0	3
8	ТС-9 “Успех” ХХК	62	62	3	0
9	ТС-10 “Сидней констракшн монголиа” ХХК	10	10	2	0
10	ТС-11 “Баян хаяабуса” ХХК	20	20	3	0
11	ТС-12 “Дабль эйт” ХХК	5	5	0	0
12	ТС-13 “Энергэтикланд” ХХК	7	7	0	0
13	ТС-14 “Тэнгэрлэг наяд” ХХК	14	14	3	2
14	ТС-15 “Булган жацо” ХХК	41	41	5	1
Нийт		280	280	29	9

Боловсон хүчний судалгаагаар 14 ААНБ нийтдээ 193 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаагаас жолооч 67, техникийн ажилтан /*ачих ажлыг гүйцэтгэдэг*/ 46, бусад ажилтан 80 байна. Нийт ажилчдын 52 нь буюу 29.9% нь нийгмийн даатгалд бүртгэлтэй үндсэн ажилтан байна. 141 нь буюу 70.1% нь үндсэн ажилтнаар бус, гэрээний үндсэн дээр ажилладаг нь тогтвор суурьшилгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Хавсралт 3.

Ачилтын үйлчилгээ эрхэлдэг ААНБ-уудын жолооч болон техникийн ажилтантай байгуулдаг гэрээг судалж үзэхэд ачилтын тооноос хамааруулан техникийн ажилтныг 5000 төгрөг, жолоочийг 8,000-15,000 төгрөгөөр цалинжуулахаар гэрээ байгуулсан байна. Энэ нь жолооч нар хэт орлогын хойноос хөөцөлдөх, журмын шаардлагыг хэрэгжүүлэхгүй байх шалтгаан болж байна. Хавсралт 4

Холбогдох байгууллагуудаас 2019 онд сургалт зохион байгуулаагүй, 2020 онд НАЗХГ, ТЦА, “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо”-оос 1 удаа үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудад “Замын хөдөлгөөний дүрэм”, “Хувь хүний ёс зүй, харилцаа хандлага” чиглэлээр сургалт зохион байгуулж ажиллажээ. Харин ААНБ нь ажилтнууддаа холбогдох сургалтын үйл ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхдээ гэрээ байгуулсан ААНБ-ууд холбогдох журмын заалтыг нарийн чанд баримтлахгүй байна.

Энэ нь тухайн ААНБ-ын тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлж буй ажилтан нь холбогдох журмыг судлаагүй, ажил олгогч байгууллага нь ажилчдадаа сургалт мэдээллийг тогтмол хийдэггүй, боловсон хүчний тогтворгүй байдал, жолооч нарыг ачилтын тооноос хамааран цалинжуулдаг, ачих үйл ажиллагаанд тавих холбогдох байгууллагын хяналт сул зэрэгтэй холбоотой байна.

Үүнээс шалтгаалж замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зорилгоо умартах, тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлэх гэрээт ААНБ-ууд орлогын хойноос хөөцөлдөх, иргэдийн бухимдлыг төрүүлэх сөрөг нөхцөл байдал үүсгэж байна.

Цаашид НАЗХГ болон “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо”, үйлчилгээ эрхлэгч ААНБ-ын хамтын ажиллагааг сайжруулах, ААНБ-ын чадавхыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, тухайн үйл ажиллагааг журмын үндсэн шаардлагад нийцүүлэх, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлж, түр саатуулах холбоотой журмыг боловсронгуй болгох, өнөөгийн хэрэгцээнд нийцүүлэх зайлшгүй шаардлага үүссэн байна.

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг сурталчилж, таниулах, ААНБ нь ажилтнууддаа холбогдох сургалтыг тогтмол зохион байгуулж хэвших шаардлагатай байна.

Иймд илэрсэн зөрчлүүдийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.


Дүгнэлт: Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахдаа журамд заасан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй нь ААНБ-ын ажиллах боловсон хүчний хөдөлгөөн, ачилтын тооноос хамаарч цалинжуулсан, ажилтнуудад сургалт хангалтгүй зохион байгуулсантай холбоотой байна.

1.4 Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, шилжүүлсэн, саатуулсан тээврийн хэрэгслийн тоо, байршилтай холбоотой мэдээлэлд судалгаа шинжилгээ хийх замаар журмын зорилгыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна уу?

2017-2020 онд хамаарах 6 дүүргийн 73 байршилд зөөж шилжүүлсэн, тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

Нийслэлд сүүлийн 4 жилд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 77,166 тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлжээ.

График 1. Зөөж, шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тоо



Графикаас харвал зөөж шилжүүлж, түр саатуулсан тээврийн хэрэгслийн тоо 2018 оныг өмнөх онтой харьцуулахад 7,273 буюу 59.0%, 2019 онд өмнөх оноос 14,518 буюу 54.0%, 2020 онд өмнөх оноос 6,307 буюу 19.0%-иар тус тус өссөн байна.


Энэ нь УБ хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 2020 онд өмнөх онуудаас 31,194-46,756-аар нэмэгдсэн ч төлбөртэй зогсоолын тоо нэмэгдээгүйтэй нэг талаас холбоотой байна.

График 2. Зөөж, шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тоог нийт тээврийн хэрэгслийн тоотой харьцуулсан байдал



Зөөж, шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тоог сараар харьцуулан харвал 9, 10 саруудад хамгийн их, 12, 1, 2 дугаар саруудад хамгийн бага байна.

График 3. Зөөж, шилжүүлсэн тээврийн хэрэгслийн тооны өсөлтийн хувь




Графикаас харвал ачилтын тоо 9, 10 дугаар сард хамгийн өндөр хувьтай байна. Энэ нь ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Нийслэлд авто замын хөдөлгөөн огцом өсөж ачаалал нэмэгдэх, авто зогсоолын талбайн хүрэлцээгүй байдалтай шууд хамааралтай байна.

2019-2020 онд хэрэгжүүлэгч байгууллага болон холбогдох бусад газруудаас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн, саатуулсан тээврийн хэрэгслийн тоо, байршилтай холбоотой мэдээлэлд судалгаа шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь НАЗХГ нь тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлэх түр саатуулах, төлбөртэй авто зогсоол ажиллуулахтай холбоотой асуудлыг нэг албан хаагчид хариуцуулснаар ажлын ачаалал нэмэгдэж дүн шинжилгээ, судалгаа хийх ажил орхигдсон байна.

НЗД-ын 2016 оны А/35, 2017 оны А/601 дүгээр захирамжаар тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгжүүдтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг НАЗХГ-т даалгасан. Гэрээний биелэлтэд хяналт хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2018, 2019, 2020 онд 6 удаагийн хяналт шалгалтыг хэрэгжүүлжээ. Үүнд:

- 2018 онд НАЗХГ-тай тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсан ААНБ-ын үйл ажиллагаанд гэрээний биелэлтэд хяналт тавихаар НАЗХГ, НОБГ, НМХГ, НТГ, ТЦА, Нийслэлийн ЗДТГ, НҮНТ-үүдийн албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсгийн дараах хяналт шалгалт хийжээ. Үүнд:



Шалгалтад Нийслэлд тээврийн хэрэгслийг зориулалтын автомашинаар зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулж байгаа 15 ААНБ хамрагдсанаас 9 ААНБ-ын гэрээг сунгасан байна. Авто машины техникийн бүрэн бүтэн байдал хангаагүй, тусгай дуут болон гэрлэн дохио ашиглаагүй, жолооч, техникийн ажилтнуудын хувийн бичиг баримт бүрэн бус, QR код бүхий НӨАТ-ын баримтын олгоогүй, түр саатуулах хашаа /байр/-нд гэрэлтүүлэг болон камержуулалд хийгээгүй “Авто гранд мастер” ХХК, “Энэргэтикланд” ХХК, “Сүлд транс” ХХК, “Тэнгэрлэг Наяд” ХХК, “Сидней констракшн Монголиа” ХХК, “Авто хүч” ХХК зэрэг 6 компанийн гэрээг сунгахгүй цуцлахаар шийдвэрлэсэн ч дээрх шалгалтаар илэрсэн алдаа дутагдлаа арилгасан 4 ААНБ-тай 2019 онд гэрээг шинэчлэн байгуулж, “Авто гранд мастер” ХХК болон “Сүлд транс” ХХК-ний гэрээг цуцалсан байна.

✚ 2019 онд НМХГ, ТЦА, НАЗХГ-аас “Зориулалтын авто машинаар тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийг боловсруулан хамтарсан ажлын хэсэг гарч хяналт шалгалт хийжээ. Тухайн шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг хугацаатай үүрэг даалгавар өгч зөрчлийг шалгалтын явцад арилгуулсан байна.

Мөн НАЗХГ, “Ачигч авто машинуудын нэгдсэн холбоо” ТББ-ууд хамтран жилд 2 удаа ажлын хэсэг гаргаж дээрх ААНБ-ын гэрээний биелэлтэд хяналт тавьж гэрээг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан дүгнэж ажилласан байна.

✚ 2020 онд КОВИД-19 цар тахал гарсантай холбогдуулан НАЗХГ-аас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагааг эрхэлж буй ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дээрх байгууллагуудаас 2018, 2019 онд хийсэн шалгалтаар илэрч байсан алдаа зөрчил тус аудитаар давтан гарч байгаа нь хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээ муу байгааг харуулж байна. Иймд илэрсэн зөрчлүүдийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: Холбогдох газруудаас гэрээний хэрэгжилт, үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтыг зохион байгуулсан ч зөрчил арилаагүй, шилжүүлсэн, саатуулсан тээврийн хэрэгслийн тоо, байршилтай холбоотой мэдээлэлд судалгаа шинжилгээ хийгээгүй байна.

БҮЛЭГ 2: НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ ТАЛБАЙД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨЛБӨРТЭЙ ЗОГСООЛ АЖИЛЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА УУ?

НИТХ-ын 2009 оны 4/27 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ын 3.1¹⁹-д заасны дагуу НАЗХГ нь Нийслэлд төлбөртэй зогсоолын үйлчилгээ явуулах эрх бүхий байгууллага байна. Дээрх тогтоолд НИТХ-ын 2011 оны 7/66 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оржээ.

2019 онд 75 байршилд /1,772 автомашины багтаамжтай зогсоол/ 75 иргэн, ААНБ, 2020 онд 70 байршилд /1,597 автомашины багтаамжтай зогсоол/ 70 иргэн, ААНБ-ын төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэхээр НАЗХГ-тай гэрээ байгуулан ажиллажээ.

Хүснэгт 9. Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэхээр гэрээ байгуулсан иргэн, ААНБ

№	Дүүрэг	Хамрах он	Гэрээ байгуулсан ААНБ /тоо/	Авто машины зогсоолын тоо
1	БГД	2019 он	13	361
2	БЗД		6	111
3	СБД		21	565
4	СХД		10	234
5	ХУД		5	58
6	ЧД		20	443
	Нийт		75	1,772
1	БГД	2020 он	14	389
2	БЗД		4	73
3	СБД		20	403
4	СХД		7	174
5	ХУД		4	47
6	ЧД		21	511
	Нийт		70	1,597

НИТХ-ын 2011 оны 7/66 дугаар тогтоолын 5.1.2-т заасны дагуу ААНБ нь төлбөртэй авто зогсоолын үйлчилгээнээс олох орлогын 60 хувийг авто замын санд төвлөрүүлэхээр байна. Үүний дагуу 2019 онд 752.2 сая төгрөг, 2020 онд 469.1 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

Нийслэлд төлбөртэй зогсоолын үйлчилгээг өөрийн эзэмшлийн талбайд, газрын зориулалтаа зөрчин /НАЗХГ-тай гэрээ байгуулаагүй/ эрхэлж буй 131 иргэн, ААНБ байна.

2.1 Нийслэлийн авто зам хөгжлийн газар нь нийтийн эзэмшлийн зам талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ үзүүлэх эрэлт, хэрэгцээг тооцож судлах, байгуулах үүргээ хэрэгжүүлсэн үү?

НИТХ-ын 2009 оны 4/27 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ын 3.1²⁰-д заасны

¹⁹ 3.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар /цаашид “хэрэгжүүлэгч байгууллага” гэх/ нь төлбөртэй зогсоолын үйлчилгээ явуулах эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллага байна.

²⁰ 3.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар /цаашид “хэрэгжүүлэгч байгууллага” гэх/ нь төлбөртэй зогсоолын үйлчилгээ явуулах эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллага байна.

дагуу НАЗХГ нь Нийслэлд төлбөртэй зогсоолын үйлчилгээ явуулах эрх бүхий байгууллага байна гэж заажээ. Хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үүрэгтэй. Үүнд:

Зогсоолын үйлчилгээний талбайн эрэлт, хэрэгцээг тооцож, судалгаа хийх, шинээр төлбөртэй зогсоол байгуулах шийдвэр гаргуулах;

Зогсоолын үйлчилгээг боловсронгуй арга хэмжээ авч ажиллах;

Төлбөртэй зогсоолын батлагдсан зураг, төслийн дагуу байгуулах;

НЗД-ын 2016 оны А/736 дугаар УБ хотын авто зогсоолын хүртээмжийг сайжруулах, гадаад орны авто зогсоолын менежментийн тэргүүн туршлагыг нутагшуулах талаар судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг НХТЕТГ-ын даргаар ахлуулан 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд НЗД-ын эдийн засаг, хөрөнгө оруулалт хариуцсан зөвлөх, нийслэлийн ЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Төсөл, хөтөлбөр хамтын ажиллагааны тасгийн дарга, НАЗХГ-ын дарга, НТА-ын дарга, НШУҮИГ-ын дарга, НГЗБА-ын дарга, ЗЦГ-ын дарга, НХОГ-ын дарга, УБЗАА гэсэн 9 агентлагийн хамтарсан дарга нарын бүрэлдэхүүнтэй гишүүдээс бүрджээ.



УБ хотын авто зогсоолын хүртээмжийг сайжруулах, гадаад орны авто зогсоолын менежментийн тэргүүн туршлагыг нутагшуулах талаар судалж танилцуулах ажлын хүрээнд УБ хотын төвийн 6 дүүрэгт нийтийн эзэмшлийн зам талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ үзүүлэх эрэлт, хэрэгцээг тооцож, судалж танилцуулжээ. Судалгааны дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. Зогсоолын талбай байгуулах судалгаа


№	Дүүрэг	Газар доорх зогсоол				Төлөвлөлт хийх боломжгүй	Нэгдсэн зогсоол /Давхар зогсоол/		Төлөвлөлт хийх боломжгүй
		Байршил /тоо/	Хүчин чадал /машин/	Байршил /тоо/	Хүчин чадал /машин/		Байршил /тоо/	Хүчин чадал /машин/	
2	БГД	7	1,884	42	2,330	1	10	2,220	2
1	БЗД	4	301	14	430	-	2	800	-
3	СБД	6	607	6	300	-	2	600	-
4	СХД	3	233	3	158	-	1	400	-
5	ХУД	3	155	3	121	-	1	100	-
6	ЧД	3	230	1	83	-	1	800	1
	Нийт	26	3,410	69	3,422	1	17	4,920	3

Судалгаагаар 26 байршилд 3,410 авто машины багтаамжтай ил зогсоол, 69 байршилд 3,422 авто машины багтаамжтай газар доорх зогсоол, 17 байршилд 4,920

авто машины багтаамжтай давхар зогсоол гэсэн 3 төрөлд хувааж нийт 26 га талбайд ойролцоогоор 11,752 авто машины зогсоол байгуулахаар тооцоолол хийсэн байна.

2021 байдлаар тооцоо судалгааны дагуу газар доорх болон давхар зогсоолыг байгуулаагүй байна. Харин дээрх ажлын хэсгийн дүгнэлт судалгаанд үндэслэж, НАЗХГ-аас 2016-2020 оны хооронд 8-75 иргэн, ААНБ-тай төлбөртэй зогсоолын гэрээ байгуулан ажилласан байна.

График 4. Гэрээ байгуулсан авто зогсоолын тоо




Ил зогсоолын талбайг нэмэгдүүлэхдээ авто замын ачаалал, хотын нутаг дэвсгэрт зорчих тээврийн хэрэгсэл, зориулалтын зогсоол, сул талбай гэх зэргийг судалсан нарийвчилсан судалгаа хийгээгүй, түүнд түшиглэсэн эрчмийг бүрэн магадлаагүй 2016 оны судалгаанд үндэслэжээ.

2019, 2020 онд зогсоолын үйлчилгээний талбайн эрэлт, хэрэгцээг тооцох, зогсоолын үйлчилгээг боловсронгуй болгох талаар судалгаа хийгдээгүй байна.

НИТХ-ын 2009 оны 4/27 журамд заасны дагуу нийтийн эзэмшлийн талбайд ажиллуулах төлбөртэй зогсоол ажиллуулах тохиолдолд батлагдсан зураг, төслийн дагуу байгуулахаар заажээ.

НАЗХГ-тай төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэхээр гэрээ байгуулсан 73 иргэн, ААНБ-ын 19 буюу 27.1% нь авто зогсоолын зураг, төслийг НЕТГ-аар батлуулжээ. Харин 51 иргэн, ААНБ буюу 72.9% нь зураг, төсөлгүй байна.

2020 онд Нийслэлийн замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газраас “УБ хотын авто зогсоолын өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ”-г тодорхойлж судалгаа шинжилгээ хийж, эрэлт хэрэгцээг тооцоолохдоо, Нийслэлийн хэмжээнд авто машины төвлөрөл, түгжрэлийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг тооцож, дээшлүүлэхээр авто машины төлбөртэй зогсоолын нарийвчилсан судалгаа шинжилгээг хийсэн байна. Үүнд:



Мөн Нийслэлийн замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газраас “УБ паркинг менежмент” ХХК-тай “Нийслэлийн нутаг дэвсгэрт зогсоолын үйлчилгээний нэгдсэн үйл ажиллагаа эрхлэх гэрээ”-г 2020 оны 6-р сард байгуулж, Авто зогсоолын удирдлагын нэгдсэн программ хангамж хөгжүүлж, жолооч болон зогсоолын

аппликейшн гаргажээ. Централ тауерийн хажуу талын нийтийн эзэмшлийн талбайд байрших зогсоолд дугаар таних камерууд байршуулж, загвар бүхий зогсоол байгуулан ажиллажээ.


Цаашид авто зогсоолын нэгдсэн системд УБ хотын нийтийн эзэмшлийн авто зогсоолуудыг бүрэн хамруулах, авто зогсоолын аппликешнийг e-mongolia.mn төрийн үйлчилгээний цахим системтэй холбохоор төлөвлөжээ.

Мөн НЗД-ын 2021 оны А/321 дугаар захирамж гарч Нийслэл УБ хотын авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, авто зогсоолоос шалтгаалсан замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, автомашины зөв хэрэглээг бий болгох зорилгоор зогсоолын нэг стандартыг нэвтрүүлэх, авто зогсоолын нэгдсэн системд шилжүүлж, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан, судалгаа шинжилгээний ажил эхэлжээ.

Дүгнэлт: Зогсоолын үйлчилгээний талбайн эрэлт, хэрэгцээг тооцох, судалгаа шинжилгээний ажлыг холбогдох бусад газруудаас хийж хэрэгжүүлсэн ч НАЗХГ-аас тодорхой судалгаа шинжилгээний ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүй байна.

2.2 Төлбөртэй зогсоолын үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулах, хяналт тавих үүргээ хэрэгжүүлсэн үү?

“Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ын 5.1.4 ²¹ -д заасны дагуу НАЗХГ нь төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхэлж буй иргэн, ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж, гэрээний биелэлтийг тооцож ажиллахаар заажээ. Гэрээгээр үйлчилгээ эрхлэгч /иргэн, ААНБ/ нь дараах үүргийг хүлээхээр байна.



НАЗХГ нь журамд заасан үйлчилгээ эрхлэгчийн үүргийг “Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхлэн явуулах тухай гэрээ”-нд бүрэн тусгаж 2019 онд 75 иргэн, ААНБ-тай, 2020 онд 70 иргэн, ААНБ-тай гэрээ байгуулжээ.

²¹ 5.1.4 Зогсоолын үйлчилгээ эрхлэхээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих

Гэрээг дүгнэхдээ НИТХ-ын 2011 оны 7/66 дугаар тогтоолын 5.1.2²², “Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхлэн явуулах тухай гэрээ”-ний 2.4.2²³, 2.4.5²⁴ тус тус заасан нийт орлогын 60%-ийг авто замын санд төвлөрүүлэх тухай журмын заалтад үндэслэсэн байна. 2019-2020 онд төлбөртэй зогсоолоос орох орлогын хэмжээ, орлого төвлөрүүлсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 11. Гэрээний дагуу орлого төвлөрүүлсэн байдал

№	Дүүрэг	Хамрах огноо	НАЗХГ-тай гэрээ байгуулсан	Жилийн орлогын хэмжээ /мян.төг/	Төвлөрүүлбэл зохих нийт орлого /мян.төг/ /60%/	Үүнээс		Иргэн, ААНБ-ын тоо
						Орлого бүрэн төвлөрүүлсэн	Дутуу төвлөрүүлсэн	
1	БГД	2019	13	277,794.0	166,676.0	153,035.0	13,641.0	3
2	БЗД	2019	6	71,627.0	42,975.0	42,975.0		
3	СБД	2019	21	474,173.0	284,504.0	248,384.0	36,120.0	1
4	СХД	2019	10	181,000.0	108,600.0	104,940.0	3,660.0	1
5	ХУД	2019	5	39,607.0	23,763.0	23,763.0		
6	ЧД	2019	20	410,783.0	246,898.0	243,016.9	3,881.1	2
	ДҮН		75	1,454,984.0	873,416.0	816,113.9	57,302.1	7
1	БГД	2020	14	329,288.5	197,573.1	197,573.1	-	-
2	БЗД	2020	4	56,202.0	33,721.2	33,721.2	-	-
3	СБД	2020	20	373,653.0	224,191.8	224,191.8	-	-
4	СХД	2020	7	127,310.0	76,386.0	76,386.0	-	-
5	ХУД	2020	4	40,250.0	24,150.0	24,150.0	-	-
6	ЧД	2020	21	520,991.0	312,594.6	312,594.6	-	-
	ДҮН		70	1,447,694.5	868,616.7	868,616.7	-	-

2019 онд 873.4 сая төгрөгийг нийслэлийн авто замын санд төвлөрүүлэхээс 816.1 сая төгрөг төвлөрүүлж, 7 иргэн, ААНБ 57,302.1 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлжээ.

Хүснэгт 12. Орлого дутуу төвлөрүүлсэн иргэн, ААНБ

№	Гэрээний дугаар	Иргэн, ААНБ-ын нэр	Мөнгөн дүн /төгрөг/
1	12	Өсөх дэлгэрэх ирээдүй ХХК	2,621,100
2	60	Иргэн Э.Энхцэцэг	1,260,000
3	52	УБЗАА	36,120,000
4	50	Иргэн Г.Баярмаа	12,456,000
5	36	УБТЗ вокзал	379,000
6	35	УБТЗ-ын удирдах газар	806,000
7	20	Авто тээврийн тав ХХК	3,660,000
	Нийт		57,302,100

Энэ нь “Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхлэн явуулах тухай” гэрээний 4.1.2²⁵-т заасныг зөрчсөн, гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн байна. Гэсэн ч Ковид-19 цар тахлын хүрээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж үйлчилгээг хязгаарлаж, иргэн, ААНБ-ын орлого тасарсантай холбоотойгоор гэрээг нь сунгажээ. Дутуу төвлөрүүлсэн дээрх 57.3 сая.төгрөгийн төлбөрийг Нийслэлийн Дотоод аудитын газрын 2021 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 38-04/02 дугаартай албан

²² 5.1.2 Хэрэгжүүлэгч байгууллага нь зогсоолын үйлчилгээнээс орох орлогын 60 хувийг авто замын санд төвлөрүүлэх

²³ 2.4.2. Үйлчилгээ эрхлэгч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 7/66 дугаар тогтоолын 5.1.2 заагдсан зогсоолын үйлчилгээний хураамжийн 60 хувийг гэрээний хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний дагуу сар бүрийн 25-ны дотор нийслэлийн замын санд төвлөрүүлэх.

²⁴ 2.4.5. Төлбөртэй зогсоолын 10 автомашины өдөр, сарын орлогын 60 хувийг тухайн сарын 25-ны дотор Нийслэлийн төрийн сан банкна дахь орон нутгийн зогсоолын төлбөр нэртэй 100200000931 тоот дансанд шилжүүлэх.

²⁵ 4.1.2 Үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагааны орлогыг тогтоосон хугацаанаас хоцроож, ажлын 5 хоногийн дотор нөхөн төлөөгүй тохиолдолд

шаардлагын дагуу төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна. Харин 2020 онд 868.6 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлжээ.

Хүснэгт 13. 1 авто машины зогсоолын төлбөр

№	Дүүрэг	Авто машины тоо			
			0-500	501-1,000	1,001-2,000
1	БГД	14	-	9	5
2	БЗД	4	-	4	-
3	СБД	21	2	11	8
4	СХД	7	3	4	-
5	ХУД	4	-	4	-
6	ЧД	21	2	6	13
Нийт		71	7	38	26

НАЗХГ нь зогсоолын үйлчилгээ эрхлэгч иргэн, ААНБ-тай байгуулсан гэрээнд төсөвт төвлөрүүлэх орлогыг тооцохдоо цагийг харилцан адилгүй тооцсоноор 1 цагийн зогсоолын үйлчилгээнээс орох орлогын хэмжээ ялгаатай байна. Хавсралт 2. Тухайлбал СБД-т байрлах төвийн байршлын зогсоолуудаас ижил хэмжээний орлогыг төсөвт төвлөрүүлэх боломжтой байтал харилцан адилгүй буюу зарим ААНБ-д 1 цагийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 148-160 төгрөгөөр, бусдад нь 1,500-1,750 төгрөг гэх мэтээр тогтоосон байна. Үүнд:

- “БСБ электроникс” ХХК-ний СБД дэх авто зогсоолын 1 авто машины 1 цагийн төлбөр 148 төгрөг;
- “Батсарай” ХХК-ний СБД дэх авто зогсоолын 1 авто машины 1 цагийн төлбөр 160 төгрөг;
- “Номадс хоспиталити” ХХК-ний СБД дэх авто зогсоолын 1 авто машины 1 цагийн төлбөр 1,750 төгрөг;
- “Туушин зочид буудал” ХХК-ний СБД дэх авто зогсоолын 1 авто машины 1 цагийн төлбөр 1,500 төгрөг байна

Дээрх байдлаас шалтгаалан “БСБ электроникс”, “Батсарай” ХХК-иудын зогсоолын тоо их байхад төсөвт төвлөрүүлэх орлого нь “Номадс хоспиталити”, “Туушин зочид буудал” ХХК-иудаас 8,7-13,8 сая төгрөгөөр дутуу байна.

Хүснэгт 14. 1 авто зогсоолын төлбөрийг гэрээгээр харилцан адилгүй тооцсон


№	ААНБ-ын нэр	Зогсоолын тоо	Зогсоолын төлбөрийн орлого		
			2019 он		
			ААНБ-ын жилийн орлого	1 авто машины зогсоолоос тооцсон төлбөрийн хэмжээ /төгрөг/	Гүйцэтгэл гэрээгээр /мян.төг/
1	БСБ электроникс ХХК	23	3,422.00	148.7	2,053.00
2	Батсарай ХХК	20	3,200.00	160.0	1,920.00
3	Номадс хоспиталити ХХК	15	26,250.00	1,750.0	15,750.00
4	Туушин зочид буудал ХХК	12	18,000.00	1,500.0	10,800.00

Энэ нь НАЗХГ нь НИТХ-ын 2011 оны 7/66 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөхгүй байх, ажлын хариуцлагагүй байдал, шат шатны хяналт хангалтгүйгээс шалтгаалж байна.

Цаашид төлбөртэй авто зогсоолын үйлчилгээнээс орох төлбөрийн хувь хэмжээг тооцох аргачлал боловсруулж батлуулах шаардлагатай байна.

Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгч 71 иргэн, ААНБ-аас төсөвт төвлөрүүлэх 1 цагийн орлогын хэмжээ нь 500 хүртэл 9.9%, 501-1,000 хүртэл 53.5%, 1,001-2,000 хүртэл төгрөгийн төлбөртэй ААНБ 36.6% нь байна.

График 5. Авто машины зогсоолоос төлбөр тооцсон байдал



НИТХ-ын 2009 оны 4/27 дугаар тогтоолын 7.1.5-д заасны дагуу төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгч иргэн, ААНБ нь хэрэгжүүлэгч байгууллагад сар, улирал, жилээр тайлан гаргаж ирүүлэхээр заасан өнөөдрийг хүртэл тайлан ирүүлээгүй байна. Дээрх зөрчлүүд илэрч байгаа нь НАЗХГ-аас гэрээний биелэлтэд тогтмол хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Мөн НИТХ-ын 2009 оны 4/27 дугаар тогтоолын 3.1²⁶-д зааснаар нийтийн эзэмшлийн зам талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ явуулах эрх бүхий байгууллага нь НАЗХГ байхаар заасан ч УБЗАА нь дараах зогсоолын талбайг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулаагүй, зохих зөвшөөрөлгүйгээр эзэмшсэн байна. Үүнд:

- ЧД Хангарьд ордны баруун тал
- СБД Спортын төв ордны баруун талын зогсоол
- ЧД Драммын театрын хойд талын зогсоол

Цаашид нийтийн эзэмшлийн зам талбайд зохих зөвшөөрөлгүй авто зогсоолын үйлчилгээ эрхэлж буй байгууллага, иргэн, ААНБ-ын судалгааг гаргаж журмын дагуу зохих арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Нийслэлд төлбөртэй зогсоолын үйлчилгээг өөрийн эзэмшлийн талбайд, газрын зориулалтаа зөрчин /НАЗХГ-тай гэрээ байгуулаагүй/ эрхэлж буй 131 иргэн, ААНБ байна. Эдгээр иргэн, ААНБ төсөвт орлого төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 15. Өөрийн эзэмшлийн талбайд, газрын зориулалтаа зөрчин авто зогсоол үйл ажиллагаа эрхэлсэн

№	Дүүрэг	Хамрах он	Зөвшөөрөлгүй зогсоолын тоо
1	БГД	2020 он	10
2	БЗД		32
3	СБД		47
4	СХД		19
5	ХУД		23
6	ЧД		
Нийт			131

²⁶ 3.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар /цаашид "хэрэгжүүлэгч байгууллага" гэх/ нь төлбөртэй зогсоолын үйлчилгээ явуулах эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллага байна.

Иймд НАЗХГ нь гэрээний хугацааг сунгахдаа холбогдох журам, гэрээний заалтыг баримталж, үүргээ биелүүлээгүй иргэн, ААНБ-д хариуцлага тооцож байх, төсөвт төвлөрүүлэх 1 цагийн орлогыг ялгавартайгаар тооцдог байдлыг арилгаж, НИТХ-аас баталсан тогтоолд нийцүүлж, өөрийн эзэмшлийн талбайд, газрын зориулалт зөрчин төлбөртэй зогсоолын эрхэлж буй иргэн, ААНБ-ын үйл ажиллагааг хэрхэн шийдвэрлэх талаар санал дүгнэлт боловсруулан эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Мөн “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам” нь нийтийн эзэмшлийн талбайд төлбөртэй зогсоол ажиллуулах харилцааг зохицуулсан. Харин иргэн, ААНБ өөрийн эзэмшил, ашиглалтын газрын зориулалтыг өөрчлөн төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхэлж буй асуудал орхигдсон байна.

Иймд илэрсэн зөрчлүүдийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: НАЗХГ нь төлбөртэй зогсоолын үйлчилгээг эрхлэх иргэн, ААНБ-тай гэрээ байгуулахдаа төлбөрийн хувь хэмжээг ялгавартай тооцсон, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй иргэн, ААНБ-д хариуцлага тооцоогүй, биелэлтэд хяналт тавих үүргээ хангалтгүй хэрэгжүүлжээ.

2.3 Төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагууд журамд заасан үүрэг, шаардлагыг хэрэгжүүлж байна уу?

“Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ын 7 дугаар зүйлд төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгч иргэн, ААНБ-д тавигдах шаардлага, хүлээх үүргийг заажээ. Үүнд:

7.1.1.	•Хариуцаж буй зогсоолын үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу эрхлэх
7.1.2.	•Орон нутгийн захиргааны байгууллагаас тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхтэй холбоотой тавьсан шаардлагыг биелүүлэх
7.1.3.	•Зогсоолын төлбөрийн төхөөрөмжийг байршуулах
7.1.4.	•Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын баталсан цагийн хуваарийг баримтлах
7.1.5.	•Хариуцаж буй зогсоолын үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу эрхлэх:
7.1.6.	•Зогсоолын тохижилтын асуудлыг бүрэн хариуцаж, шаардлагатай засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх
7.1.7.	•Зогсоолын ажилчдыг зориулалтын хувцас, хөдөлмөрийн багаж шаардлагатай тоног төхөөрөмж болон бусад техник хэрэгслээр хангах
7.1.8.	•Зогсоолыг хашаа, хайсаар хашиж хаахгүй байх

Аудитаар дээрх шаардлагыг хангаж буй эсэхийг төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхэлж буй 70 иргэн, ААНБ-аас 48 буюу 68.5%-ийг түүвэрт хамруулан газар дээр нь тулган баталгаажуулж ажиллахад дараах байдалтай байна. Хавсралт 5. Үүнд:

- Зогсоолын талбайд зориулалтын хаалт хийгээгүй 8 буюу 16.6%;
- Камержуулалтын систем байрлуулаагүй, байрлуулсан ч ажиллагаагүй 12 буюу 25%;

- Галын болон түргэн тусламжийн машины зориулалтын зогсоолгүй нь 26 буюу 54.2%
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам талбайгүй 24 буюу 50%;
- Хүснэгт 16. Төлбөртэй зогсоолын талбай шаардлага хангаж буй эсэх**

№	Дүүрэг	НАЗХГ-тай гэрээ байгуулсан	Тулган баталгаа	Зориула	Камержу	Галын болон	Хөгжлийн бэрхшээлт
1	БГД	12	9	1	-	3	3
2	БЗД	5	2	-	-	0	0
3	СБД	19	14	3	3	9	7
4	СХД	7	3	-	3	3	3
5	ХУД	5	4	1	1	3	3
6	ЧД	22	16	3	5	8	8
	Нийт	70	48	8	12	26	24

Зогсоолын талбайд төлбөрийн систем байрлуулсан эсэх, төлбөрийн баримт өгч буй эсэхийг тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Төлбөрийн электрон системгүй байршуулаагүй 18;
- Төлбөрийн баримт өгөөгүй 22 иргэн, ААНБ байсан.

Хүснэгт 17. Төлбөртэй зогсоолын талбайд төлбөрийн систем байрлуулж төлбөр авч буй байдал

№	Дүүрэг	Тулган баталгаажуулалт хийсэн	Тээврийн хэрэгслийн зогсоолын тоо	Зогсоолын талбай дахь бодит тоо	Төлбөрийн электрон системгүй	Төлбөрийн баримт өгдөггүй
1	БГД	9	310	484		1
2	БЗД	2	48	55	0	0
3	СБД	14	453	510	6	6
4	СХД	3	85	105	2	3
5	ХУД	4	62	80	1	1
6	ЧД	16	434	661	9	11
	Нийт	48	1,392	1,895	18	22

Төлбөртэй зогсоолыг гэрээнд тусгасан багтаамжийн дагуу ашиглаж байгаа эсэхийг түүвэрт хамрагдсан 48 иргэн, ААНБ-ын хүрээнд тодруулахад НАЗХГ нь гэрээндээ 1,399 тээврийн хэрэгслийн зогсоолоор тооцсон ч газар дээр нь 1,895 буюу 506 тээврийн хэрэгслийг илүү байршуулсан байна.

Энэ нь НАЗХГ-аас тухайн иргэн, ААНБ-тай гэрээ байгуулахдаа 1 авто машины зогсоолыг 18м²-аар тооцсон ч үйлчилгээ эрхлэгч иргэн, ААНБ нь зогсоолын талбайд тээврийн хэрэгсэл хоорондын зайг шахаж байршуулдагтай холбоотой байна.

Дээрх зөрчлүүд илэрч байгаа нь НАЗХГ-аас гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүйтэй холбоотой байна.

Цаашид төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхэлж буй иргэн, ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж журамд заасан шаардлагад нийцүүлэн гэрээг шинэчлэх байгуулах, төлбөртэй зогсоол ажиллуулах журмыг боловсронгуй болгох, өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх шаардлага үүссэн байна.

Иймд илэрсэн зөрчлүүдийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: Түүвэрт хамрагдсан иргэн, ААНБ-ууд нь төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэх журамд заасан үүрэг, шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам” нь өнөөгийн бодит хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.
2. Тээврийн хэрэгслийг зөөх, тээвэрлэх журамд тусгасан “замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх” зорилгыг бүрэн хангаагүй, ачих журамлах чиглэлийг түлхүү баримтлан ажилласан байна.
3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дугаар тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-д тусгасан шаардлагууд, НИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 33/35 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлд тээврийн хэрэгслийг зориулалтын автомашинаар зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа байр ажиллуулах журам”-д тусгасан шаардлагуудыг үйлчилгээ эрхлэгч ААНБ-ууд мөрдөөгүй, эрх бүхий байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.
4. Үйлчилгээ эрхлэгчид нь ажилтнууддаа эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм журмыг таниулаагүй, сургалт зохион байгуулаагүй, ачиж журамласан тээврийн хэрэгслийн тоонд үндэслэсэн урамшууллыг бий болгосон нь журмын үндсэн зорилгыг хангахад бус ашгийн төлөө ажиллахад хүргэсэн байна.
5. Шилжүүлсэн, саатуулсан тээврийн хэрэгслийн тоо, байршилтай холбоотой мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийгээгүй байна.
6. Нийт 131 иргэн, ААНБ эзэмшил, ашиглалтын газрын зориулалтыг зөрчин гэрээгүйгээр төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхэлж байна.
7. НАЗХГ-аас төлбөртэй зогсоолын үйлчилгээг эрхлэх иргэн, ААНБ-ын гэрээнд цагийг харилцан адилгүй тооцсоноор төсөвт орлого оруулах боломжийг алдсан байна.
8. Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгчид нь зогсоолын талбайд зориулалтын хаалт хийгээгүй, камержуулалтын болон төлбөрийн электрон систем байршуулаагүй, галын болон түргэн тусламжийн машины зориулалтын зогсоол гаргаагүй, төлбөрийн баримт өгөхгүй зөрчил түгээмэл гаргаж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д:

1. Тээврийн хэрэгслийг зөөх, тээвэрлэх журам нь зорилго, зорилтоо хангаж буй эсэхэд дүн шинжилгээ хийн, хэрэгжилт үр дүнг тооцох, шинэчлэн сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч, цаашдын чиглэлээ тодорхойлох;
2. Төлбөртэй зогсоол ажиллуулах журмыг өнөөгийн бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэх;
3. Цаашид холбогдох журмуудад тусган баталсан шаардлагуудыг үйлчилгээ эрхлэгч иргэн, ААНБ заавал мөрддөг хөшүүргийг бий болгож, үйл ажиллагаанд нь эрх бүхий байгууллагаас тавих шат шатны хяналтыг сайжруулах.

Нийслэлийн Автозамын хөгжлийн газрын дарга /Г.Баярсайхан/-д

1. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагаанд талуудын оролцоог жигд хангаж НАЗХГ болон “Ачигч авто машинуудын холбоо” НҮТББ үйлчилгээ эрхлэгч ААНБ-ын хооронд гэрээ байгуулж үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
2. Холбогдох журмуудад тусган баталсан шаардлагуудыг үйлчилгээ эрхлэгч иргэн, ААНБ-аар заавал мөрдүүлж, гэрээнд тусгасан эрх, үүрэг, хариуцлагыг баримталж ажиллах;
3. Иргэд олон нийтэд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг сурталчилж, таниулах, ААНБ-аар ажилтнууддаа холбогдох сургалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;
4. Ачиж журамласан тээврийн хэрэгслийн тоонд үндэслэн цалин, урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох;
5. Төлбөртэй зогсоолын үйлчилгээнээс төсөвт төвлөрүүлэх цагийг жигд тооцож, иргэн, ААНБ-уудад харилцан адилгүй ялгавартайгаар тогтоосон байдлыг засаж, НИТХ-ын баталсан төлбөрийн хэмжээг баримтлах;
6. “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам” нь нийтийн эзэмшлийн зам талбайд гэх нэршил хэр оновчтой эсэх, эзэмшил, ашиглалтын газрын зориулалтыг зөрчин төлбөртэй зогсоол эрхэлж буй иргэн, ААНБ-ын үйл ажиллагааг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал, дүгнэлт боловсруулан эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;
7. Ачиж журамлах болон төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт, ААНБ-ын тээврийн хэрэгслийн болон мэргэшсэн жолоочийн бэлэн байдалд тавих хяналтыг сайжруулж, үйл ажиллагааг нь чадавхжуулах, шат шатны хяналтыг сайжруулан, хяналтын шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх;
8. Төлбөртэй авто зогсоолын үйлчилгээнээс орох төлбөрийн хувь хэмжээг тооцох аргачлал боловсруулж батлуулах.

Холбогдох байгууллагын санал



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0088

Утас: 32-53-85, Факс: (976-11) 32-44-98

E-mail: Info@road.ub.gov.mn

<http://www.road.ub.gov.mn>

	2021.09.14	№	2/1630
танай	2021.09.07	-ны №	990

Нийслэл дэх төрийн аудитын газарт

Танай газраас ирүүлсэн 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 990 дугаартай “Нийслэлд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, саатуулах, төлбөртэй зогсоол ажиллуулах журмын хэрэгжилт”-д хийсэн аудитын /НАГ-2021/89-ШТА-ГА/ тайлангийн төсөл, мэдэгдэлд саналгүй болно.



Нийслэлийн Авто Замын Хөгжлийн Газар
Удирдлага
Даргын Албан Үүргийг Түр Орлон Гүйцэтгэгч
Ганболд Баярсайхан
2021.09.14 16:23

Саналд өгсөн тайлбар

НАЗХГ-ын 2021 оны 9 дүгээр сарын 14-ны өдрийн 2/1630 дугаар албан бичгээр аудитын тайлангийн төсөлд тусгагдсан асуудалтай санал нэг байгааг илэрхийлсэн.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлж, түр саатуулсан орлогын зарцуулалт /2020 он/

/сая.төг/

№	ААНБ-ын нэр	2020 он ачилт тоо хэмжээ	Мөнгөн дүн/	Жолооч, техник ажилтан зардал	Удирдлагын зардал	Тхтс байр, түрээсийн	Шатахуун зардал	Heat	Автомашин элэгдэл, хорогдо	Ндш	Сэлбэг	Дугуйн элэгдэл	Шатах тослох материал	Ашиг
1	Батзэв ххк	9,022	541.3	115.3	86.9	73.9	57.1	49.2	44.2	24.2	11.3	9.3	5.7	64.2
2	Баян хаяабуса ххк	3,450	207.0	44.1	33.2	28.3	21.8	18.8	16.9	9.3	4.3	3.6	2.2	24.5
3	Успех ххк	3,413	204.8	43.6	32.9	27.9	21.6	18.6	16.7	9.2	4.3	3.5	2.2	24.3
4	Би икс юу ти ХХК	3,216	193.0	41.1	31.0	26.3	20.4	17.5	15.7	8.6	4.0	3.3	2.0	22.9
5	Их тээвэр ХХК	2,820	169.2	36.0	27.2	23.1	17.9	15.4	13.8	7.6	3.5	2.9	1.8	20.1
6	Булган ЖАЦО ХХК	2,511	150.7	32.1	24.2	20.6	15.9	13.7	12.3	6.7	3.2	2.6	1.6	17.9
7	Юу эн пи эм жи эл ххк	1,587	95.2	20.3	15.3	13.0	10.0	8.7	7.8	4.3	2.0	1.6	1.0	11.3
8	Энергэтикланд ХХК	1,482	88.9	18.9	14.3	12.1	9.4	8.1	7.3	4.0	1.9	1.5	0.9	10.5
9	Тэнгэрлэг наяд групп ХХК	1,424	85.4	18.2	13.7	11.7	9.0	7.8	7.0	3.8	1.8	1.5	0.9	10.1
10	Авто гоулд транс ххк	1,350	81.0	17.2	13.0	11.1	8.5	7.4	6.6	3.6	1.7	1.4	0.9	9.6
11	Бодь транс ххк	980	58.8	12.5	9.4	8.0	6.2	5.3	4.8	2.6	1.2	1.0	0.6	7.0
12	Дабль эйт ХХК	926	55.6	11.8	8.9	7.6	5.9	5.1	4.5	2.5	1.2	1.0	0.6	6.6
13	Сидней констракшн монголиа ххк	733	44.0	9.4	7.1	6.0	4.6	4.0	3.6	2.0	0.9	0.8	0.5	5.2
14	Авто хүч ХХК	230	13.8	2.9	2.2	1.9	1.5	1.3	1.1	0.6	0.3	0.2	0.1	1.6
Нийт		33,144	1,988.6	423.4	319.4	271.4	209.9	180.8	162.2	88.9	41.7	34.2	21.0	235.8

Хавсралт 2

1 авто машинаас орох орлогыг гэрээгээр харилцан адилгүй тооцсон

№	ААНБ-ын нэр	Зогсоолын тоо	Зогсоолын төлбөрийн орлого		
			2019 он		
			ААНБ-ын жилийн орлого	1 авто машины зогсоолоос тооцсон төлбөрийн хэмжээ /төгрөг/	Гүйцэтгэл гэрээгээр /мян.төг/
1	Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ	200	238,000.00	1,190.00	142,800.00
2	Г.Баярмаа	115	60,720.00	528.00	36,432.00
3	Улаанбаатар төмөр зам	70	52,500.00	750.00	31,500.00
4	Ногоон тэнгис ХХК	65	40,625.00	625.00	24,375.00
5	Бөмбөгөр ложистик ХХК	50	62,500.00	1,250.00	37,500.00
6	Гоо мөнх фарм ХХК	50	68,750.00	1,375.00	41,250.00
7	Өсөх дэлгэрэх ирээдүй ХХК	40	44,000.00	1,100.00	26,400.00
8	Минж өгөөж ХХК	40	40,000.00	1,000.00	24,000.00
9	Сонгинохангай ХХК	40	40,000.00	1,000.00	24,000.00
10	Их хар гомбо ХХК	40	11,000.00	275.00	7,020.00
11	Түрэлт ХХК	35	26,250.00	750.00	15,750.00
12	Нар-Урт ХХК	35	8,680.00	248.00	5,208.00
13	Хөрс-авто сервис ХХК	31	15,500.00	500.00	9,300.00
14	Гурвангал ХХК	30	18,750.00	625.00	11,250.00
15	Улаанбаатар төмөр зам	30	16,500.00	550.00	9,900.00
16	Бичигт булган ХХК	30	15,000.00	500.00	9,000.00
17	Бий секьюрити ХХК	30	15,000.00	500.00	9,000.00
18	У.Цолмон	30	14,700.00	490.00	8,820.00

19	Цэгц ХХК	30	26,850.00	895.00	16,110.00
20	Чимо ХХК	30	25,680.00	856.00	15,408.00
21	Т.Жавхлантөгс	28	14,336.00	512.00	8,601.00
22	Ю.Батсайхан	26	19,500.00	750.00	11,700.00
23	Монголын үндэсний бөхийн холбоо	25	13,275.00	531.00	7,965.00
24	Ди Эйч Ти ХХК	24	36,000.00	1,500.00	21,600.00
25	БСБ электроникс ХХК	23	3,422.00	148.78	2,053.00
26	Тэмжин ХХК	22	16,500.00	750.00	9,900.00
27	Ш.Баатархуяг	21	23,625.00	1,125.00	14,175.00
28	Маргад шилтгээн ХХК	20	20,000.00	1,000.00	12,000.00
29	Жэтро холдинг ХХК	20	20,000.00	1,000.00	12,000.00
30	Түрэлт ХХК	20	12,660.00	633.00	7,596.00
31	Ц.Ганбаатар	20	11,760.00	588.00	7,056.00
32	Тайжийн шонхор ХХК	20	12,000.00	600.00	7,200.00
33	Баянзүрх дүүргийн "Нийтлэг үйлчилгээний нэгдсэн авто бааз" ОНӨААТҮГ	20	18,336.00	916.80	11,001.00
34	Б.Бат-Ууган	20	4,240.00	212.00	2,544.00
35	Батсарай ХХК	20	3,200.00	160.00	1,920.00
36	Монголын үйлдвэрчний эвлэлийн соёлын төв өргөө	19	19,000.00	1,000.00	11,400.00
37	М.Тэмүүжин	17	5,956.00	350.35	3,574.00
38	Викторицентр ХХК	16	24,000.00	1,500.00	14,400.00
39	Ханбүргэдэй ХХК	15	22,500.00	1,500.00	13,500.00
40	Номадс хоспиталити ХХК	15	26,250.00	1,750.00	15,750.00
41	Рокмон ХХК	15	13,125.00	875.00	7,875.00
42	Интер интернэйшнл глобал ХХК	15	14,112.00	940.80	8,476.00
43	Засгийн газрын байруудын "Нийтлэг үйлчилгээний газар" ОНӨААТҮГ	15	10,875.00	725.00	6,525.00
44	Скай пийпл ХХК	14	10,500.00	750.00	6,300.00
45	Туушин зочид буудал ХХК	12	18,000.00	1,500.00	10,800.00
46	Акела сэкьюрити ХХК	12	15,000.00	1,250.00	9,000.00
47	Халиун төгөл ХХК	11	6,908.00	628.00	4,144.00
48	Чингэс колл ХХК	10	6,250.00	625.00	3,750.00
49	Бодь цамхаг ХХК	10	20,000.00	2,000.00	12,000.00
50	Авто тээврийн тав	10	15,000.00	1,500.00	9,000.00
51	БСБ электроникс ХХК	10	12,000.00	1,200.00	7,200.00
52	ЗСНБ ХХК	10	17,500.00	1,750.00	10,500.00
53	Улаанбаатар зочид буудал ХХК	10	8,950.00	895.00	5,370.00
54	Эх газар ХХК	10	6,536.00	653.60	3,921.00
55	Хатагтай ХХК	10	3,340.00	334.00	2,004.00
56	Д.Мөнхзул	10	7,920.00	792.00	4,752.00
57	Э.Энхцэцэг	10	6,350.00	635.00	3,810.00
58	Жэй эн моторс тур ХХК	10	3,810.00	381.00	2,286.00
59	Сэрүүлэг их сургууль	10	5,440.00	544.00	3,264.00
60	Рааш булаг ХХК	10	2,650.00	265.00	1,590.00
61	Эфэсконстракшн ХХК	9	2,889.00	321.00	1,733.00
62	Улаанбаатар синема ХХК	8	5,000.00	625.00	3,000.00
63	Астра интернэйшнл ХХК	8	6,000.00	750.00	3,600.00
64	Ийст гарден ХХК	8	6,000.00	750.00	3,600.00
65	А.Сэлэнгэ	8	8,000.00	1,000.00	4,800.00
66	БСБ электроникс ХХК	7	8,400.00	1,200.00	5,040.00
67	Боса ХХК	7	2,709.00	387.00	1,625.00
68	Галхувь ХХК	5	5,625.00	1,125.00	3,375.00
69	Ц.Даваадорж	5	1,160.00	232.00	696.00
70	Номгон гол ХХК	4	1,120.00	280.00	672.00
71	Өлзийн дэн ХХК	2	2,500.00	1,250.00	1,500.00

Нийт дүн	1727	1,421,234.00	853,166.00
----------	------	--------------	------------

Хавсралт 3

Боловсон хүчний талаарх мэдээлэл /жолооч, техникийн ажилтан/

№	ААНБ-ын нэр	Нийт ажилтны тоо	Үүнээс			Үүнээс нийгмийн даатгал төлдөг		
			Жолооч	Техникийн ажилтан	Нийт	Жолооч	Техникийн ажилтан	Нийт
1	Булган ЖАЦО ХХК	18	6	6	12	3	2	5
2	Тэнгэрлэг наяд групп ХХК	14	4	4	8	0	0	0
3	Бат зэв ХХК	34	12	12	24	3	3	6
4	Дабль эйт ХХК	11	2	2	4	2	1	3
5	Сидней констракшн монголиа ХХК	6	3	1	4	3	1	4
6	Авто хүч ХХК	7	3		3	2	0	2
7	Авто гоулд транс ХХК	11	6	1	7	2	0	2
8	Би Икс Юу Ти ХХК	15	5	3	8	4	2	6
9	Бодь транс ХХК	6	2	2	4	1	1	2
10	Баян хаяабуса ХХК	12	4	4	8	4	4	8
11	Успех ХХК	18	5	1	6	5	0	5
12	Их тээвэр ХХК	14	6	4	10	3	3	6
13	Энергэтикланд ХХК	17	6	6	12	0	0	0
14	Юу Эн Пи Эм Жи Эл ХХК	10	3		3	3	0	3
Нийт		193	67	46	113	35	17	52

Хавсралт 4

Жолооч болон техникийн ажилтны цалинг хөдөлмөрийн гэрээнд тусгасан байдал

№	Аанб-ын нэр	Нэг ажилчны цалингийн хэмжээ	Хөдөлмөрийн гэрээний холбогдох заалт	1 машин ачилтад цалинждаг хэмжээ
1	Булган ЖАЦО ХХК	Хийснээр	1.4 дэх заалт	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
2	Тэнгэрлэг наяд групп ХХК	Хийснээр	2.3 дахь заалт	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
3	Бат зэв ХХК	Хийснээр	1.12.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
4	Дабль эйт ХХК	Хийснээр	2.7.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
5	Сидней констракшн монголиа ХХК	Хийснээр	2.2.1.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
6	Авто хүч ХХК	Хийснээр, Тогтмол	3.2.11.	Жолооч-15.000, Техникийн ажилтан-500.000 /сард/
7	Авто гоулд транс ХХК	Хийснээр	1.2.1.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
8	Би Икс Юу Ти ХХК	Хийснээр	1.4.2.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
9	Бодь транс ХХК	Хийснээр	1.2.1.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
10	Баян хаяабуса ХХК	Хийснээр	1.8.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
11	Успех ХХК	Хийснээр	2.2.1.	Жолооч-8.000, Техникийн ажилтан-5.000
12	Их тээвэр ХХК	Хийснээр	1.8.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000

13	Энергэтикланд ХХК	Хийснээр	2.1.	Жолооч-10.000, Техникийн ажилтан-5.000
14	Юу Эн Пи Эм Жи Эл ХХК	Тогтмол	2.2.1.	Жолооч-600.000 /сард/, Техникийн ажилтан-500.000 /сард/

Хавсралт 5

Зогсоолын талбайн стандарт

№	ААНБ-ын нэр	Дүүрэг	Эзэмшиж буй зогсоолын тоо	Бодит тоо	Зогсоолын талбай шаардлага хангаж байгаа эсэх			
					Зориулалтын хаалттай эсэх /1-тийм, 0-үгүй/	Камержуулалтын систем байрлуулсан эсэх /1-тийм, 0-үгүй/	Төлбөрийн электрон систем байрлуулсан эсэх /1-тийм, 0-үгүй/	Төлбөрийн баримт өгч буй эсэх /1-тийм, 0-үгүй/
1	АКЕЛА СЕКЬЮРИТИ ХХК	СБД	12	12	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
2	Астра-Интернэйшнл ХХК	ХУД	8		Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
3	Бичигт Булган ХХК	СБД	30	45	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
4	Бодь цамхаг ХХК	ЧД	10		Тийм	Тийм	Тийм	Тийм
5	Бөмбөгөр ложистикс ХХК	ЧД	50	135	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
6	БСБ электроникс ХХК	ЧД	10	16	Тийм	Тийм	Тийм	Тийм
7	Викторицентр ХХК	ЧД	16	30	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй
8	Гоо мөнх фарм ХХК	ЧД	50	50	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
9	Грийт эмпайр ХХК	СБД	28	28	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
10	Гурван гал ХХК	СБД	30	30	Тийм	Тийм	Тийм	Тийм
11	Гурван мөнх хаан ХХК	ЧД	23	30	Тийм	Тийм	Тийм	Тийм
12	ДИ ЭЙЧ ТИ ХХК	БГД	24	24	Тийм	Тийм		Үгүй
13	Жетро холдинг ХХК	ХУД	20	20	Тийм	Тийм	Тийм	Тийм
14	ЗСНБ ХХК	СБД	10	10	Тийм	Үгүй	Тийм	Тийм
15	Интер интернэйшнл глобал ХХК	ЧД	15	30	Тийм	Тийм	Тийм	Тийм
16	Их Монгол товер ХХК	ЧД	36	36	Тийм	Үгүй	Үгүй	Тийм
17	Их хар гомбо ХХК	ЧД	40	55	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
18	Л.Баярт-Од	ХУД	25	40	Тийм	Тийм	Тийм	Тийм
19	Маргад шилтгээн ТББ	БГД	20	27	Тийм	Тийм	Тийм	Тийм
20	Минж Өгөөж ХХК	СХД	35	35	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
21	Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам	БГД	30	30	Тийм	Тийм	Тийм	Тийм

22	Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам	БГД	70	115	Тийм	Тийм	Тийм	Тийм
23	НАР-УРТ ХХК	СБД	35	35	Тийм	Тийм	Тийм	Үгүй
24	Ногоон тэнгис ХХК	ЧД	65	91	Тийм	Тийм	Тийм	Үгүй
25	Номадс хоспиталиги ХХК	СБД	15	28	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй
26	Ө.Анхболор	БГД	115	115	Тийм	Тийм	Тийм	Тийм
27	Өлзий дэн ХХК	БГД	2	5	Тийм	Тийм	Тийм	Тийм
28	Өсөх дэлгэрэх ирээдүй ХХК	ЧД	40	40	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
29	Рааш булаг ХХК	ЧД	10	20	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй
30	Рокмон ХХК	БГД	15	33	Тийм	Тийм	Тийм	Тийм
31	Сандай плазад бизнес эрхлэгчид цэлмэг төв ГҮТББ	БЗД	28	35	Тийм	Тийм	Тийм	Тийм
32	Скай пийпл ХХК	СБД	15	24	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй
33	Сонгинохангай ХХК	СХД	40	40	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
34	Тайжийн шонхор ХХК	СБД	20	20	Тийм	Тийм	Тийм	Тийм
35	Төгс гэрэлт цамхаг ХХК	СБД	61	61	Тийм	Тийм	Тийм	Тийм
36	Туушин зочид буудал ХХК	СБД	12	12	Тийм	Тийм	Тийм	Тийм
37	Түрэлт ХХК	СБД	35	35	Тийм	Тийм	Тийм	Тийм
38	Түрэлт ХХК	СБД	20	20	Тийм	Тийм	Тийм	Тийм
39	УБЗЗАГ Талбайн урд	СБД	130	150	Тийм	Тийм	Тийм	Тийм
40	Улаанбаатар синема ХХК	ЧД	8	13	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
41	Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордон	БГД	19	120	Тийм	Тийм	Тийм	Тийм
42	Хан бүргэдэй ХХК	БГД	15	15	Үгүй	Тийм	Үгүй	Тийм
43	Ц.Ганбаатар	БЗД	20	20	Тийм	Тийм		Тийм
44	ЧИМО ХХК	ЧД	30	50	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй
45	Чингэс Колл ХХК	СХД	10	30	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
					Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
46	Ш.Баатархуяг	ЧД	21	45	Тийм	Тийм	Тийм	Тийм
47	ЭФЭСКОНСТРАК ШН ХХК	ХУД	9	20	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
48	Эх газар ХХК	ЧД	10	20	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Нийт			1392	1895	8	12	18	22